



МОНГОЛ УЛС
ДОРНОД АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 79

Чойбалсан

Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх
дэд хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”, мөн 2019 оны 335 дугаар тогтоолоор баталсан “Биеийн тамир, спортыг 2020-2023 онд хөгжүүлэх” үндэсний хөтөлбөрийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн “Үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийг жил бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, орон нутгийн төсөвт тусган, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн хамтын ажиллагаа, иргэдийн оролцоонд түшиглэн хэрэгжүүлж, үр дүнг тооцож ажиллахыг аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Л.ХИШИГТОГТОХ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 12
дугаар сарын 02-ны өдрийн 79 дүгээр
тогтоолын хавсралт

ДОРНОД АЙМАГТ ҮНДЭСНИЙ БӨХИЙН СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ ДЭД ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн үндэслэл:

Монгол Улсын Засгийн газрын 2019 оны дөрөвдүгээр сард 153 дугаар тогтоолоор 2019-2027 онд “Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлого”-ыг батлаж, мөн оны наймдугаар сард 335 дугаар тогтоолоор “**Биеийн тамир, спортыг 2020-2023 онд хөгжүүлэх**” үндэсний хөтөлбөр тус тус батлагдан гарсан.

Үндэсний бөхийн түүхэнд манай аймгийн даншиг наадмын аваргууд О.Гэлэгсэнгэ, О.Дугар монголын бахархал нь байж, 1930-1940-өөд онд улсын цолтой бөхчүүдээрээ манлайлж байсан түүхтэй.

2006 оноос хойш 11 жилийн дараа 2017 онд Улсын начин цолтон төрж, амжилтаа ахиулан 2019 онд Улсын харцага цолонд хүрсэн.

Аймгийн хэмжээнд 2019 оны байдлаар 640 хүн үндэсний бөхөөр идэвхитэй хичээллэж, Улсын цолтой 3 бөх барилдаж, 21 аймагтаа 16 дугаарт эрэмблэгдэж байна.

Төрөөс биеийн тамир, спортын талаар баримтлах бодлогын баримт бичигт “Бие бялдрын сорилын 2017 оны судалгаагаар өсвөр үеийнхний 80.2 хувь нь тухайн насныхаа бие бялдрын хөгжлийн түвшингээс доогуур, илүүдэл жин, таргалалтын түвшингээр Ази тивдээ хамгийн өндөр, нийт хүн амын 55 хувь нь илүүдэл жин, таргалалттай гэсэн дүгнэлт гарсан” гэж тэмдэглэсэн байна.

Манай аймгийн “Хүн амын бие бялдрын хөгжилт чийрэгжилтийн түвшинг тогтоох сорил”-д энэ онд хамрагдсан нийт хүн амын 47 хувь нь С, D, F үнэлгээтэй, 15-64 насныхан 6,3 хувь нь туранхай, 35,22 хувь нь илүүдэл жинтэй, 20 шахам хувь таргалалтын 1-3-р зэрэгтэй байна.

2019 оны цэрэг татлагын нэгдүгээр ээлжийн үзлэгт 531 залуучууд орсноос 357 буюу 67,2 хувь нь тэнцээгүй, хоёрдугаар ээлжийн үзлэгт 470 залуучууд орсноос 260 буюу 55,5 хувь нь эрүүл мэндээр тус тус тэнцээгүй буюу энэ онд нийт 1031 залуучууд орсноос 617 буюу 59,49 хувь нь бие бялдар, болоод эрүүл мэндийн шаардлага хангаагүйн улмаас цэргийн албанд тэнцээгүй байна.

Иймд монгол үндэсний бөхөөр барилддаг, хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлэх, өсвөр үе залуусыг үндэсний уламжлалт бөхийн ёс дэг жаягт сургаж, хүмүүжүүлэх, биеийн тамир, спортоор тогтмол хичээллүүлэх, чийрэгжүүлэх, эрүүлжүүлэх хэрэгцээ шаардлага байна.

Дорнод аймагт үндэсний бөхийн спортыг хөгжүүлэх хөтөлбөр нь Үндэсний өв соёл, зан заншлыг үндэсний бөхөөр дамжуулан түгээн дэлгэрүүлэх, хойч үедээ өвлүүлэх, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, сэтгэлийн хаттай, эрүүл чийрэг залуу үеийг бэлтгэн хөгжүүлэх, ирээдүйтэй тамирчдын бэлтгэл сургалтыг шинжлэх ухааны үндэслэлтэй бэлтгэж, улсын цолтой бөхчүүдийн тоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хөтөлбөрийн зорилго:

Монгол үндэсний их баяр наадам, төрийн ёслол, зан уламжлал бүхий бөхийн спортын дэг жаяг, их өв соёлоор өсвөр залуу үеэ хүмүүжүүлж, тив, дэлхий, үндэсний хэмжээнд алдар цолтой бөхчүүдийн залгамж халааг тогтвортой бэлтгэнэ.

Хөтөлбөрийн зорилт:

Зорилт 1. Монгол үндэсний бөхөөр дамжуулан эх оронч, эрүүл чийрэг, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, сэтгэлийн хаттай үндэсний өв соёл, зан заншлаа дээдэлсэн залуу үеийг бэлтгэн хөгжүүлэх

Зорилт 2. Шинжлэх ухаанч, үндэслэл судалгаатай тогтмол бэлтгэл сургалт явуулдаг багш дасгалжуулагч бүхий дэвжээдийн тоог нэмэгдүүлж, дэвжээ бүрийн тамирчдын идэвхтэй залгамж халаатай байж, улсын цол, тив, дэлхийн энтэй бөхчүүдийн чансааг өсгөнө.

Хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл

Монгол үндэсний бөхөөр дамжуулан эх оронч, эрүүл чийрэг, бие бялдрын өв тэгш хөгжилтэй, сэтгэлийн хаттай үндэсний өв соёл, зан заншлаа дээдэлсэн залуу үеийг бэлтгэн хөгжүүлэх нэгдүгээр зорилтын хүрээнд:

1.1. Аймгийн нийт сум, Дорнод их сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, ерөнхий боловсролын сургууль бүр дэргэдээ үндэсний бөхийн дэвжээ, багш дасгалжуулагчтай болж, тогтмол, тасралтгүй хичээллэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлнэ.

1.2. Үндэсний бөхийн дэвжээгээр дамжуулан орон нутгийн иргэд, өсвөр залуу үеийг сургах, хүмүүжүүлэх, хичээллүүлэх, хөгжүүлэх, дасгалжуулах ажлыг тогтмол тасралтгүй зохион байгуулна.

1.3. Монгол үндэсний халх, буриад, барга, үзэмчин ястны бөхийн уламжлал, дэг ёс, арга мэх, дэвээ дэвэлтийг хүүхэд, залууст өвлүүлэн эзэмшүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх барилдааныг уламжлал болгоно.

Шинжлэх ухаанч, үндэслэл судалгаатай тогтмол бэлтгэл сургалт явуулдаг багш дасгалжуулагч бүхий дэвжээдийн тоог нэмэгдүүлж, дэвжээ бүрийн тамирчдын идэвхтэй залгамж халаатай байж, улсын цол, тив, дэлхийн энтэй бөхчүүдийн чансааг өсгөх хоёрдугаар зорилтын хүрээнд

2.1. Үндэсний бөхийг шинжлэх ухаанч, үндэслэл судалгаатай тогтмол бэлтгэл сургалт явуулдаг багш, дасгалжуулагч, бөхийн хөлийн цэц, засуул, цолчин засуул, гарын даа, тайлбарлагч нарыг нэмэгдүүлнэ.

2.2. Нийт ажил олгогч, клуб, дэвжээнүүд хамтран, үндэсний бөхөөр хичээллэж байгаа иргэд, тамирчдын тоог нэмэгдүүлэх, эрч хүч, авхаалж самбаа, ёс жудагыг дээдэлсэн монгол үндэсний бөхийн барилдааны чансааг ахиулсан уламжлалт барилдааныг аймгийн хэмжээнд тогтмол зохион байгуулна.

2.3. Аймаг, бүс нутаг, ард түмний хүндэтгэл хүлээсэн дэвжээ, дасгалжуулагч, тамирчдыг бэлтгэх, дэмжих, урамшуулах, олон нийтэд танилцуулах соёл, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.

Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа:

2020 оноос 2023 оныг дуустал 4 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилт:

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- Улсын болон орон нутгийн төсөв

- олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;
- бусад эх үүсвэр.

Дэд хөтөлбөрийн хүрэх үр дүн:

- 3.1. Сум бүр мэргэжлийн багш, дасгалжуулагч бүхий бөхийн дэвжээтэй болсон байна.
- 3.2. Өсвөр залуу үе үндэсний бөхөөр хичээллэж, идэвхтэй дасгал хөдөлгөөн, спортоор хичээллэж, чийрэгжих орчин бүрдсэн байна.
- 3.3. Монгол үндэсний халх, буриад, барга, үзэмчин ястны бөхийн соёлыг өвлүүлэх ажил уламжлал болсон байна.
- 3.4. Төрийн болон төрийн бус байгууллагууд, бөхийн холбоодын хамтын ажиллагаа идэвхжиж, бөхийн барилдааны уламжлалт тэмцээн уралдааны чансаа сайжирсан байна.
- 3.5. Аймгийн хэмжээнд тамирчдын ур чадварыг ахиулах, спортын сургалт-дасгалжуулалт, тэмцээн, наадмын шаталсан тогтолцоотой болж, үндэсний хэмжээнд аймаг, дэвжээнийхээ нэрээр овоглосон бөхийн цолтон болон тамирчид нэмэгдсэн байна.
- 3.6. Аймаг, бүс нутаг, ард түмний хүндэтгэл хүлээсэн дэвжээ, дасгалжуулагч, тамирчдыг бэлтгэх, дэмжих, урамшуулах, олон нийтэд танилцуулах соёл, нөлөөллийн ажил тогтмолжсон байна.

Дэд хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт, хяналт-шинжилгээ, үнэлгээ

- 4.1. Аймгийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар нь дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг баталж, зохион байгуулалтыг нь хариуцаж ажиллана.
- 4.2. Аймгийн Биеийн тамир, спортын газар нь дэд хөтөлбөрийг сумын Засаг даргын Тамгын газар, нийт ажил олгогч, төрийн бус байгууллагууд, клуб, дэвжээдтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 4.3. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр, аймгийн Засаг даргын Тамгын газарт тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас жил тутамд, явцын болон эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хөндлөнгийн үнэлгээний багаар хоёр жил тутамд хийлгэнэ.
- 4.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлтэд үндэслэн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх гүйцэтгэлийн арга хэмжээний төлөвлөгөө, шалгуур үзүүлэлтэд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу нэмэлт, өөрчлөлт оруулж болно.